


# ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ

## НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2026 оны 1 дугаар сарын 3-ны өдрийн байдлаар буюу **эхний долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 12 аймагт **76** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



### Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 76 тохиолдлын 88% /67/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 12% /9/ нь орон нутагт (Баян-Өлгий /4/, Төв /5/) бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **15** тохиолдол Хан-Уул дүүрэгт бүртгэгдсэн байна.

# 1 ДҮГЭЭР ДОЛОО ХОНОГТ

(2025.12.28 – 2026.1.3)


2026 оны эхний долоо хоногт 76 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 59.8 хувиар, 5 жилийн дунджаас 31.9 хувиар тус, тус буурсан үзүүлэлттэй байна.

Угаарын хийн цочмог хордлогын тохиолдлын хөдлөл зүй




## ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эхний долоо хоногт** нийт **32** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.



Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 30-39 насны иргэд хамгийн их хордлогод өртөж байна.

2026 оны **эхний долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **32** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеээс 166.7 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 247.8 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эхний долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	3	17	20
2	Эмийн хордлого	6	6	12
<b>Нийт</b>		<b>9</b>	<b>23</b>	<b>32</b>

Нийт 32 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 12 (38%) нь эмийн хордлого, 20 (68%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 23 (72%) тохиолдол, санаатай хордлого 9 (18%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.